

МОНГОЛ УЛС ДҮРВЭГСДИЙГ ХҮЛЭЭН АВАХ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮССЭН ҮЕИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Я.Ариунболд

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Хилийн албаны удирдлага, стратегийн профессорын багийн профессор, хурандаа

Түлхүүр үг: Дүрвэгсэд, орогнол, хүний эрх, үндэсний аюулгүй байдал, бодлого, төлөвлөлт, арга хэмжээ

Key words: Refugees, asylum, human rights, national security, policy, planning and action

Товч агуулга: Дайн дажин, зэвсэгт мөргөлдөөн, байгалийн гамшиг зэрэг аюул заналхийллийн улмаас дүрвэгсдийн асуудал дэлхий нийтийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Ялангуяа хөрш орнууд болон бүс нутагт цэрэг-улс төрийн байдал тогтворгүй байгаа өнөө үед Монгол Улсад дүрвэгсэд бөөнөөр орж ирэх эрсдэл магадлал байсаар байгаа тул энэхүү асуудлыг зохицуулах үндэсний хариу арга хэмжээний удирдлагын тогтолцоог бэхжүүлэх нь чухал ач холбогдолтой.

Abstract: Due to threats such as wars, armed conflicts, and natural disasters, the issue of refugees has become one of the pressing problems of the world. Especially at a time when the military-political situation in the neighboring countries and regions is unstable, there is still a possibility of a mass influx of refugees into Mongolia, so it is important to strengthen the national response and management system to manage this problem.

Оршил. Дүрвэгсдийн асуудал нь дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө тулгамдаж буй хамгийн төвөгтэй асуудлын нэг бөгөөд тавиад онд дүрвэгсдийн ихэнх нь европчууд, жар далаад онд африкчууд, наяд онд латин америкууд байсан бол өнөөдөр ихэнх нь Ази, Африк, Ойрх дорнодын дүрвэгсэд болоод байна. Аюул заналхийллийн улмаас аргагүйн эрхэнд амь зулбаж хоргодох газар хайж дүрвэн дайжсан хүмүүсийг хамгаалах нь хүн төрөлхтний хүнлэг ёсны эртний уламжлал, үнэт зүйл төдийгүй

эдүгээ олон улсын хүний эрхийг хамгаалах салшгүй нэг хэсэг болжээ.

Дүрвэгсдийг хамгаалах олон улсын чиг үүрэг нь дүрвэгсдийг буцаахаас урьдчилан сэргийлэх, орогнол хүсэгчийн хүсэлтийг шийдвэрлэхэд туслах, хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, дүрвэгсдийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, сайн дурын үндсэн дээр эх оронд нь буцаахад болон нүүлгэн шилжүүлэхэд туслалцаа үзүүлэх явдал юм.

Дүрвэгсдийн эрх зүйн байдлын

тухай 1951 оны конвенцыг НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар 70 гаруй жил тууштай хэрэгжүүлж, олон улсад дүрвэгсдийг хамгаалах эрх зүйн орчныг бэхжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж байна. 2016 оны есдүгээр сард баталсан Дүрвэгсэд, цагаачдын тухай Нью-Йоркийн тунхаглалд НҮБ-ын гишүүн 193 улс бүгд нэгдсэн нь дүрвэгсдийг хамгаалах үндсэн зарчмыг хүн төрөлхтөн хүлээн зөвшөөрч байгааг харуулж байна.

Дүрвэгсдийг хүлээн авах улсад учирдаг нийтлэг бэрхшээл нь дүрвэгсэдтэй холбогдсон онцгой нөхцөл байдлыг зохицуулах, эмэгтэй дүрвэгч, хүүхэд, гэр бүлийг хамгаалах, дүрвэгч нэрээр орж ирсэн хүн тус бүрийн статусыг тогтоох, дүрвэлтийн асуудлаар урт хугацааны баттай шийдлийг олох явдал байна.

Дүрвэгсэд нь хяналтгүй шилжилт хөдөлгөөнийг бий болгох, хууль бусаар хил нэвтрэх, гэмт хэрэг өсөх, эдийн засгийн болон байгалийн баялаг эзэмших талаар өрсөлдөгч болох, нутгийн иргэдтэй зөрчил мөргөлдөөн үүсгэх зэргээр хүлээн авагч улс, бүс нутагт сөрөг нөлөө үзүүлж байна. Үүний улмаас зарим улс оронд үндэсний аюулгүй байдал, эдийн засаг, хүн ам зүйн эрх ашгийн үүднээс дүрвэгсдийн орогнол авах эрхийг хязгаарлах, хил хязгаараа хаах, цагдан хорих зэрэг саад тавих асуудал ажиглагдаж байна.

Дүрвэгсэд, цагаачдын тухай 2016 оны Нью-Йоркийн тунхаглалд үндэслэн, дүрвэгсдийг хүлээн авч

буй орнуудад учирч буй дарамт шахалтыг багасгах, хамтран ажиллах, тусламж дэмжлэг үзүүлэх зорилготой Дүрвэгсдийн дэлхийн гэрээг НҮБ-аас 2018 онд баталсан.

Цаашид олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс дүрвэгсдийн асуудлыг удаан хугацаанд тогтвортой шийдвэрлэх зорилгоор эх оронд нь буцаахгүй байх зарчмаас татгалзаж, тэднийг сайн дурын үндсэн дээр нутаг буцаах, нийгэмшүүлэх, гуравдагч орны дэмжлэгт тулгуурлах зэрэг шинэ арга замыг эрэлхийлж байгаа нь Монгол Улсын дүрвэгсдийн талаар баримтлах бодлого, үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр нийцэж байна.

Энэхүү өгүүлэлд Монгол Улсад дүрвэгсдийн асуудлыг зохицуулж буй өнөөгийн онцлог, дүрвэгсэд бөөнөөр орж ирэх үед төрөөс баримтлах бодлого, авах арга хэмжээ, төрийн байгууллагуудын үүрэг хариуцлага, удирдлага, менежментийн тогтолцоог тусгалаа.

НЭГ. ДҮРВЭГСДИЙН АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсад дүрвэгсдийн асуудлыг гадаадын иргэн, цагаач гэдэг ойлголтын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Гадаадын иргэн, харьяатын газар хариуцан зохицуулж байна.

Монгол Улсын хууль тогтоомжид гадаадын иргэн, дамжин өнгөрөгч, түр ирэгч, хувийн хэргээр оршин суугч, албан хэргээр

оршин суугч, харьяалалгүй хүн, цагаач зэрэг торхойлолтуудыг тусгасан боловч яг дүрвэгсдийн талаар албан ёсны томъёолол байхгүй байна.

Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1,8-д “цагаач” гэж Монгол Улсын эрх бүхий байгууллагаас цагаачлан оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хэлнэ гэж тодорхойлсон байна⁴⁵.

Монгол Улс дүрвэгсдийн олон улсын гэрээ конвенцод нэгдэн ороогүй учраас үндэсний хууль тогтоомж, баримт бичгүүдэд дүрвэгсэдтэй холбоотой нэр томъёо, агуулгыг ашигладаггүй, зөвхөн судалгаа, шинжилгээний ажлын хүрээнд зарим эрдэмтэн судлаачид бүтээлдээ хэрэглэж байна.

БХЭШХ-гээс эрхлэн гаргасан Цэргийн нэр томъёоны тайлбар тольд: “Дүрвэгсэд гэж иргэний дайн, дайн байлдаан, дотоодын хямрал, мөрдлөг хавчлага, улс төр, шашин шүтлэг, үндэс угсааны шалтгаанаар амь насанд нь аюул заналхийлсний улмаас өөрийн эх орноос дайжин гарсан иргэд”⁴⁶ хэмээн нийтлэг байдлаар тодорхойлжээ.

Монгол Улс 1951 оны Дүрвэгсдийн конвенц болон 1967 оны нэмэлт Протоколд нэгдэх талаар Засгийн газар хэд хэдэн удаа хүчин чармайлт гаргаж байжээ. Тухайлбал, 2009 онд Дүрвэгсдийн конвенцод нэгдэн орох талаар Засгийн газрын хуралдаан,

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлсэн байдаг. 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: “Итгэл үнэмшил, улс төрийн болон бусад үйл ажиллагааны улмаас хэлмэгдсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүн, мөн шударга ёсны төлөө явж буй хүмүүсийн үндэслэл бүхий хүсэлтийн үндсэн дээр Монгол Улсаас орогнол олгож болно”⁴⁷ хэмээн заасан нь гадаад улсын дүрвэгсдийн Монгол Улсад орогнох эрхийг баталгаажуулсан үндэсний эрх зүйн зохицуулалт юм. Хэрвээ Монгол Улсын хилээр орж ирж байгаа хүн өөрийн улс оронд ямар нэгэн байдлаар хүний эрх, эрх чөлөө нь ноцтой зөрчигдөх, улс төрийн үзэл бодол, арьс өнгө, шашин шүтлэгээрээ ялгаварлан Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль 2010 он гадуурхагдах үндэслэл байвал Монгол Улсад «орогнол хүсэх» эрхээр хангах бодлого баримталж байна.

Монгол Улс дүрвэгсдийн олон улсын эрх зүйн байдлын гол зарчим болох эх оронд нь “буцаан шилжүүлэхгүй байх” зарчмыг хүндэтгэн үзэж, дүрвэгсдийг хамгаалах талаарх заалтыг биелүүлсээр ирсэн.

Тухайлбал, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3-д гадаадын иргэнд улс төрийн орогнол хүсэх эрхийг нь үндэсний хууль тогтоомжоор давхар

⁴⁵ Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1,8

⁴⁶ Цэргийн нэр томъёоны тайлбар толь

⁴⁷ Монгол Улсын үндсэн хууль 18 дугаар зүйлийн 4 дэх хэсэг

баталгаажуулсан явдал юм.

Монгол Улсын 1990 онд нэгдэн орсон Хүүхдийн эрхийн конвенцын 22 дугаар зүйлд: “Оролцогч улсууд эцэг эх нь буюу өөр бусад хүн дагалдсан эсэхийг үл харгалзан дүрвэгчийн эрх олж авахыг хүссэн буюу дагаж мөрдөж байгаа олон улсын буюу дотоодын хууль, журмын дагуу дүрвэгч хэмээн тооцогдох хүүхдэд энэхүү Конвенц болон тухайн орны нэгдэн орсон хүний эрхийн буюу хүмүүнлэгийн олон улсын бусад баримт бичигт заасан эрхээ эдлэхэд зохих хамгаалалт, хүмүүнлэгийн туслалцаа үзүүлэх шаардлагатай арга хэмжээг авна” хэмээн заасан нь Монгол Улс Дүрвэгсдийн конвенцод нэгдээгүй ч хүний эрх, хүмүүнлэгийн бусад нэгдэн орсон олон улсын эрх зүйгээр дүрвэгсдийг хамгаалах үүрэг хүлээж байна.

1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 14 дүгээр зүйлд заасанчлан, “Хэн боловч мөрдөлт мөшгөлтөөс зугтаж, өөр улсад орогнох боломжийг эрэлхийлэх болон орогнох эрхтэй⁴⁸” гэсэн заалтыг түүнд нэгдэн орсон Монгол Улс тууштай хэрэгжүүлж байна⁴⁹. Мөн олон улсын орогнол хүсэгч, дүрвэгсдийн хамгаалалтыг хангах зорилгоор Монгол Улс, НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар (ДАЭДКГ)-тай 2007 онд харилцан ойлголцох “Санамж бичиг” байгуулж, дүрвэгсдийн бичиг баримт бүрдүүлэх, оршин суух зөвшөөрөл

олгох, дүрвэгсдийн статусыг тодорхойлох, орогнол хүсэгчид болон дүрвэгсдэд тусламж үзүүлэх, тэдэнд зориулсан удаан хугацааны тогтвортой шийдлүүдийг тодорхойлох талаар НҮБ-ын холоогдох агенлаг, гадаад улсын Засгний газар, талуудтай хамтран ажиллаж, дүрвэгсдийн асуудлаар олон улсын өмнө хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж байна. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа орогнол хүсэгч, дүрвэгсдийг хамгаалах үүднээс НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газраас Монгол Улсыг дүрвэгсдийн гэрээ конвенцод элсүүлэх, үндэсний хууль тогтоомжид зохицуулалт хийх талаар эрх зүйн дэмжлэг үзүүлсээр ирсэн.

Монгол Улс Иргэний болон улс төрийн эрхийн тухай болон Хүүхдийн эрхийн тухай конвенцод нэгдэн орж, үндэсний хууль тогтоомжид: “Монгол Улсын нутаг дэвсгэрт төрсөн хүүхэд нь Монгол Улсын харьяат байх”-аар хуульчилсан нь дүрвэгсдийн хүүхдүүд харьяалалгүй болохоос урьдчилан сэргийлсэн, хүүхэд бүрийн иргэншил авах эрхийг хангасан үндэсний хууль эрх зүйн чухал зохицуулалт юм.

Монгол Улсад дүрвэгсдийн тухай тусгайлсан хууль байхгүй тул НҮБ-ын ДАЭДКГ нь Монгол Улсад орогнол хүссэн хүмүүсийн дүрвэгсдийн статусыг тодорхойлох, бүртгэх, тогтоох асуудлыг үндсэндээ

⁴⁸ Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948 он

⁴⁹ Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948 он

хариуцаж, дүрвэгсэд болон орогнол хүсэгчдэд тодорхой хэрэгцээний амьдрах байраар хангахад туслалцаа үзүүлж байна.

Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газраас хүлээн зөвшөөрөгдсөн дүрвэгсэд, орогнол хүсэгчид болон бусад холбогдох иргэдийг хамгаалан туслалцаа үзүүлэхэд НҮБ-ын дүрвэгсдийн асуудал хариуцсан дээд комиссар болон бусад хүмүүнлэгийн байгууллагатай хамтран ажиллаж байна.

Монгол Улсын хуулиар НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газраас хүлээн зөвшөөрсөн дүрвэгсэд болон орогнол хүсэгчдэд тухайлсан эрх зүйн статус олгодоггүй, дүрвэгсэд албадан гаргалтаас хамгаалагдсан байдаг боловч дүрвэгсэд болон орогнол хүсэгчдэд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгодоггүй нь Монгол Улсын Үндэсний байдлын үзэл баримтлалын 3-р 3.1.3.5-д тусгасан Тадаадын харьяалалгүй хүн, цагаачдын зохист түвшнийг хадгалж, мэдээллийн тогтолцоо, эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно” гэсэн үндэсний хүн ам зүй, хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой холбоотой. Монгол Улсын хуулиар дүрвэгсдийн статус олгодоггүй тул орогнол хүсэгчид ерөнхийдөө төрөөс үзүүлдэг эрүүл мэнд, боловсрол зэрэг суурь үйлчилгээг авах боломжгүй ч тэдгээр нь НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газрын дэмжлэгтэйгээр хувийн эмнэлгээр үйлчлүүлэх

боломжтой.

ХОЁР.МОНГОЛ УЛСАД ДҮРВЭГСЭД ОРЖ ИРЭХ ҮЕИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Монгол Улсад өнөөдөр ганц нэгээрээ орж ирж байгаа дүрвэгсдийн асуудлыг зохих ёсоор шийдвэрлэж байгаа боловч цаашид дүрвэгсэд улсын хил дээр хэдэн зуу, мянгаараа бөөгнөрч, үй олноороо орж ирэхэд төрийн холбогдох байгууллагууд, тухайлбал, цагаачлалын алба, тусгай алба, хилийн алба бэлэн байх шаардлага урган гарч байна. Хамгийн эхэнд улсын хил дээр үүрэг гүйцэтгэж буй хилийн цэргийн анги, салбарын бие бүрэлдэхүүн, хилийн хяналтын байгууллагууд үүрэг хүлээхээр байна.

Хил хамгаалах байгууллагын хувьд хууль тогтоомжид заагдсан эрх хэмжээний хүрээнд улсын хил дээр тухайн иргэдийг тогтоон барих, хилийн боомтоор хил нэвтрэх эрхийн баримт бичгийг үндэслэн Улсын хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Харин дүрвэгсдийн асуудлаар зохицуулсан үйл ажиллагааны дүрэм, журам одоогоор байхгүй байгаа нь хүндрэл учруулж болзошгүй юм.

Тухайлбал, дүрвэгсдийг хилээр оруулалгүй олон хоногоор тогтоон барих нь тэдгээрийн амь нас, эрүүл мэнд, хүний эрхийн асуудал хөндөгдөж, нөхцөл байдал улам хурцдаж, хилчидтэй мөргөлдөөнд хүргэх аюул эрсдэлтэй учраас НҮБ-ын Дүрвэгсдийн

асуудал эрхэлсэн дээд комиссарын газар (ДАЭДКГ)-ын хяналтын дор хилээр нэвтрүүлж, түр байр буюу хуаранд байрлуулах нь дүрвэгсдийн асуудлыг эв зүйгээр зохицуулах эхний алхам болно гэж үзэж байна. Ийм нөхцөл байдал үүссэн үед тэднийг хэн гэж тодорхойлох, хэрхэн ажиллах зэрэг асуулт ар араасаа гарч ирэх болно. Цаашдаа олон улсын болон үндэсний эрх зүйн зарчмаар дүрвэгсдийг улсын хил зөрчсөн, зөрчөөгүй, улс төрийн орогнол хүсэгч гэх мэтээр статусыг нь тодорхойлох нарийн, төвөгтэй асуудалтай тулгарах төлөвтэй байна.

Олон улсын эрх зүйн хүрээнд гол баримтлах 1948 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолоор баталсан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ын 13 дугаар зүйлд “Хэн боловч улсынхаа дотор чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй; Хэн боловч аливаа улс орныг, түүний дотроо эх орноо орхин явах, эх орондоо эргэж очих эрхтэй” гэж заасан. Гэвч дүрвэн ирж байгаа хүнийг хүлээн авахыг улс орнуудад үүрэг хүлээлгэсэн заалт байхгүй байна. Тэгэхээр дүрвэгсэдтэй холбоотой олон улсын конвенцод нэгдээгүй, үүрэг хүлээгээгүй Монгол Улсын хувьд өөрийн үндэсний аюулгүй байдлыг хангах, эрх ашгаа хамгаалах хүрээнд дүрвэгсдийг хүлээн авах эсэх шийдвэрээ бие даан гаргах нь нээлттэй байна. Мөн түүнчлэн олон улсын туршлагаас харахад дүрвэгсдийн дунд террорист, хүүхэд цэрэг (child soldier), гэмт хэрэгтэн, бүлэглэлүүд халхавчаар орж ирэх

магадлал өндөр байдаг. Дүрвэгсдийн эмзэг байдлыг ашиглан хүний наймааны хохирогч болгох, улсын хилээр нэвтрүүлэхийг хязгаарласан эд зүйлийг болгох зорилгоор дүрвэгсэд ашиглагдахыг үгүйсгэх аргагүй юм. Монгол Улсын оршин буй бүс нутаг дахь их гүрнүүдийн хооронд геополитикийн зөрчил улам бүр хурцадсан, “шинэ хүйтэн дайн”-ны нөхцөл байдал үүсээд байгаа өнөө үед дүрвэгсдийн үндэсний аюулгүй байдалд учруулах аюул эрсдэл, цаашид авах арга хэмжээ, бодлого, төлөвлөлтөд анхаарлаа хандуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Үүссэн нөхцөл байдалд нэн даруй ямар шуурхай хариу арга хэмжээг авах, үүнд зохих байгууллагууд ямар үүрэг оролцоотой, үйл ажиллагаа нь ямар уялдаатай байх, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь олон улсын хууль болон дотоодын бодлого, хууль эрх зүйн аливаа зөрчилгүй байх, Монгол Улсын аюулгүй байдлын болон гадаад бодлогын зарчимтай уялдсан, эрх ашигт нийцсэн гэх зэрэг олон шалгуурыг хангах шаардлагатай.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар аливаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, тухайн иргэний харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтоож, үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэл гаргавал Монгол Улсад орогнох эрх олгох боломжтой гэсэн заалт байгаа тул олон мянган дүрвэгсэд үүнийг

ашиглаж орогнох өргөдөл гаргах төлөвтэй байна. Түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлалт тогтоосон нь орогнол олгохоос татгалзах нэг үндэслэл болж байна. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3 дугаар зүйлийн 3.1.2.3-д: Гадны дүрвэгсэд олноор хил даван орж ирэх, гэнэтийн хяналтгүй нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх бэлэн байдлын тогтолцоог бүрдүүлж, эрх зүй, улс төр, дипломатын цогц арга хэмжээ авна” хэмээн заасан нь дүрвэгсдийн улмаас үүсэж болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний бодлого, төлөвлөлт, бэлэн байдал, удирдлага, менежментийн тогтолцоо зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна. Мөн Онц байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд дараах нөхцөл байдал бий болсон үед онц байдал зарлаж болно хэмээн тусгасан байдаг. Үүнд:

1.Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал тохиолдсон;

2.Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч

хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр товхиуулах боломжгүй болсон.

Эдгээр хуулийн заалтууд нь бөөнөөр орж ирэх дүрвэгсдийн асуудлыг зохицуулах бодлого, үйл ажиллагаа, удирдлагын тогтолцооны эрх зүйн гол үндэслэл болж байна.

ГУРАВ. ДҮРВЭГСДИЙН АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ НЬ

Дүрвэгсдийн хуаран буюу түр байрлах газар нь Монгол Улсын хилээр бөөнөөр дүрвэн орж ирсэн гадаадын иргэд болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг улсын хилээр нэвтрүүлэх боомтын ойролцоо бүс нутагт Засгийн газраас тогтоосон тусгай хэрэгцээний газар юм.

Дүрвэгсэд нэрээр орж ирсэн олон улсад эрэн сурвалжлагдаж байгаа, олон улсын энх тайвны эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн, Нэгдсэн Үндэстний Байгууллагын зорилго, зарчимд харш үйлдэл хийсэн, улсын хилээр орж ирэхээс өмнө эрүүгийн хүнд гэмт хэрэгт холбогдсон этгээдэд олон улсын хамгаалалт үзүүлэхгүй байх, улмаар тодорхой хугацаагаар баривчлан хорих үндэслэлтэй.

Дүрвэгсдийн асуудлыг зохицуулах удирдлагын тогтолцоо нь хилээр нэвтрүүлэх, байрлуулах, санал хүсэлт өргөдөл хүлээн авах, хурууны хээний бүртгэл хийх, бие

даасан ярилцлага хийх, мэдээллийн үнэн зөвийг шалгах, дүрвэх шалтгаан, нөхцөл байдлыг иж бүрэн судлах, шаардлагатай бол нэмэлт ярилцлага хийх, орогнох статусыг хүлээн зөвшөөрөх, татгалзах, эх оронд буцаах, гуравдагч улс руу шилжүүлэх зэргээс бүрдэнэ.

Арван найман нас хүрээгүй, эцэг эх, асран хамгаалагчийн хамт Монгол Улсын нутаг дэвсгэрт дүрвэн ирсэн хүүхдийн асуудлыг олон улсын Хүүхдийн эрхийн конвенцийн дагуу шийдвэрлэнэ. Эцэг, эх нь байхгүй дүрвэн ирсэн хүүхдийн асуудлыг асран хамгаалагчийн өргөдлөөр, асран хамгаалагч байхгүй бол НҮБ-ын ДАЭДКГ-ын өмгөөллөөр шийдвэрлэнэ.

Монгол Улсад орогнох хүсэлтэй арван найман нас хүрсэн хүн өөрийн биеэр буюу итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан улсын хил дээр бол хилийн албанд, хилээс дотогш бол цагаачлалын албанд өргөдлөө бичгээр гаргах үүрэгтэй.

Хэрэв дүрвэгч нь эрүүл мэндийн шалтгаанаар биечлэн өргөдөл гаргах боломжгүй бол өргөдөл, холбогдох эмнэлгийн баримт бичгийг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан ирүүлж болно.

Улсын хилээр бөөнөөр нэвтрэх үед хилийн албанд гаргасан дүрвэгчийн өргөдлийг ХЗДХЯ-ны харьяа Цагаачлалын албанд нутаг дэвстэрийн харьяаллаар шилжүүлнэ.

Монгол Улсад орогнох хүсэлт гаргасан хүн бүрийн үндэсний

гадаад паспорт, түүнтэй зэрэгцэх баримт бичгийг хураан авч, асуудлыг шийдвэрлэх хүртэл орогнох хүсэлт гаргаж буй хүнийг тодорхойлсон баримт бичиг буюу түр гэрчилгээг олгоно.

Арван найман нас хүрээгүй орогнол хүсэгчийн мэдээллийг эцэг, эхийн аль нэгнийх нь гэрчилгээнд, эцэг эх нь байхгүй бол асран хамгаалагчийн гэрчилгээнд тусгана. Гэрчилгээний хэлбэр, олгох, солилцох журмыг ХЗДХЯ тогтооно.

Орогнох хүсэлтийг дараах үндэслэлээр нь Монгол Улсын эрх бүхий байгууллагууд хэлэлцэхээс татгалзаж болно. Үүнд:

-Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэгт холбогдсон бол;

-Эдийн засаг, нийгмийн шалтгаанаар дүрвэн орж ирсэн бол;

-Энх тайвны эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг эсвэл хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг зэрэг олон улсын эрх зүйд тусгагдсан гэмт хэрэг үйлдсэн бол;

-Хүсэлт гаргагч нь гуравдагч улсын иргэншилтэй бол;

-Дүрвэгч нь дэлхийн аюулгүй улсын жагсаалтад багтдаг улсаас ирсэн бол;

-Хүсэлт гаргагч нь худал мэдээлэл өгөх буюу мэдээлэл өгөхөөс татгалзсан бол;

-Хүсэлт гаргагч нь өргөдлөө үндэслэлийн дагуу хэлэлцэхээс татгалзсан бол;

-Хүсэлт гаргагчийг эрх бүхий тусгай албадаас үндэсний аюулгүй байдалд ноцтой аюул учруулж болзошгүй этгээд гэж үзсэн бол;

-Орогнол хүсэгч нь террорист, хэт даврагч, түүнчлэн хориглосон

үйл ажиллагаанд оролцсон болон шашны байгууллагын зорилгоор ирсэн зэрэг тохиолдол багтана.

Орогнол хүсэгчдэд Монгол Улс орогнол олгохоос татгалзсан бол тэдгээр нь тус улсын нутаг дэвсгэрээс сайн дураараа гарах ёстой. Сайн дураараа гарахаас татгалзсан тохиолдолд албадан гаргах ажиллагааг ХЗДХЯ, Хилийн алба, Цагаачлалын алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба, Цагдаагийн албатай хамтран гүйцэтгэнэ.

Орогнол хүсэгчид Монгол Улс дараах эрх үүргийг ноогдуулж болно. Үүнд:

-Орчуулагчийн үйлчилгээг авах, дүрвэгсдийг хүлээн зөвшөөрөх журам, тэдний эрх, үүргийн талаархи мэдээлэл, түүнчлэн энэ зүйлд заасны дагуу бусад мэдээ, мэдээллийг авах;

-Засгийн газраас тогтоосон журмын дагуу оршин суугаа газартаа шуудан харилцаа холбооны туслалцаа авах;

-Засгийн газраас тогтоосон журмын дагуу мөнгөн тэтгэмж авах;

-Өөр түр байршуулах төвд шилжүүлэх хүсэлт гаргах;

-Засгийн газраас тогтоосон журмаар түр байрлах байранд хоол хүнс хүлээн авах, нийтийн аж ахуйн үйлчилгээг ашиглах; Тогтоосон журмын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээ авах;

-Тогтоосон журмын дагуу түр байрлах байранд мэргэжлийн сургалтад хамрагдах, түр хөдөлмөр эрхлэх;

-Орогнох хүсэлт, өргөдлөө буцаан авах, сайн дураараа эх орондоо буцах, гуравдагч улс руу шилжин явах хүсэлт гаргах;

-Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх;

-Оршин суугаа түр байрлах байрны дотоодод тогтоосон дүрмийг дагаж мөрдөх;

-Түр байрлах байранд оршин суухдаа ариун цэврийн болон эрүүл ахуйн стандартын тогтоосон шаардлагыг дагаж мөрдөх;

-Эрүүл мэндийн байгууллагаас тогтоосон журмын дагуу явагдах эрүүл мэндийн үзлэгт заавал хамрагдах;

-Орогнол олгохоос татгалзсан эрх бүхий байгууллагын шийдвэрийг эсэргүүцэж, давж заалдах.

Дүгнэлт. Дүрвэгсдийн асуудал нь хүний эрхийг дээдэлсэн дэлхийн ниитийн тулгамдсан асуудал боловч хүн ам цөөн, газар нутаг томтой Монгол Улсын хувьд үндэсний аюулгүй байдлыг хангах асуудалтай тэнцвэржүүлж шийдвэрлэх нь зүйтэй. Одоогоор Монгол Улсад дүрвэгсдийн асуудлыг үндэсний хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын бусад эрх зүйн гэрээгээр зохицуулж байгаа ч олон улсын цэрэг-улс төрийн тогтворгүй нөхцөл байдал, халдварт өвчин, дайн дажин, хямрал, байгалийн гамшиг зэргээс зугатсан дүрвэгсэд улсын хилээр их хэмжээгээр бөөнөөрөө орж ирсэн тохиолдолд авах хариу арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө, удирдлагын тогтолцоо, оролцогч талуудын үүрэг

хариуцлагыг тодотгож, олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагуудыг татан оролцуулсан дадлага, сургуулилтыг тогтмол явуулах нь зүйтэй.

НҮБ тэргүүтэй олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс Монгол Улсыг дүрвэгсдийн олон улсын гэрээ конвенцод нэгдэхийг удаа дараа ятгаж, уриалж байгаа боловч тэдгээрт элсэх, эсэх асуудлаар судалгаа хийх, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх нь зүйтэй.

Алс ирээдүйд дэлхийн дулаарал, хэт халалт, далайн түвшин нэмэгдэх зэргээс үүдэлтэй экологийн дүрвэгсэд арлын орнууд, экваторын бүсийн орнуудаас Монгол Улсыг чиглэх магадлалтай.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

- 1.Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1948 он
- 2.Хүүхдийн эрхийн конвенц. 1990 он
- 3.Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц. 1951 он
- 4.Дипломат харилцааны тухай Венын конвенц. 1961 он
- 5.Дүрвэгсдийн тухай Картагенийн тунхаглал. 1984 он
- 6.Монгол Улсын Үндсэн хууль.1992 он
- 7.Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010 он
- 8.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль. 2010 он